



ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ
ᠭᠣᠪᠢ-ᠠᠯᠲᠠᠢ ᠠᠶᠢᠮᠭᠢᠨ
ᠵᠠᠰᠠᠭ ᠳᠠᠷᠭᠢᠨ
ᠵᠠᠬᠢᠷᠠᠮᠵᠢ

МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 11 сарын 11 өдөр

Дугаар ᠕/699

Алтай хот

Хяналтын тооллогыг зохион
байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Статистикийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2 дахь хэсэг, Засгийн газрын 2003 оны 224 дүгээр тогтоол, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар баталсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.4 дэх заалт, 4.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Мал, тэжээвэр амьтад, хашаа, худгийн 2022 оны тооллогын ажилд хяналт тавьж ажиллах чиглэл, бүрэлдэхүүнийг нэгдүгээр хавсралтаар, зардлыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Хяналтын тооллогын томилолт, шатахуун, хэвлэлтийн зардалд шаардагдах 3,000,000 (гурван сая) төгрөгийг мал тооллогын зардлаас гаргахыг Засаг даргын Тамгын газар (Ш.Эрдэнэбат)-т зөвшөөрсүгэй.


3. Сумдын мал тооллогын комиссын ажилтай танилцан, гарсан зөрчил дутагдлыг тухайн орон нутгийн холбогдох ажилтнуудтай хамтран шийдвэрлэн үнэлэлт дүгнэлт өгч, гарсан дүгнэлтийг аймгийн мал тооллогын комисст танилцуулахыг аймгийн Засаг даргын орлогч (Г.Чинбат)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



О.АМГАЛАНБААТАР

Аймгийн Засаг даргын 2022 оны
11. дугаар сарын 14. өдрийн 1/699 дугаар
захирамжийн хоёрдугаар хавсралт



ЗАРДЛЫН ТООЦОО

Явах чиглэл	Явах байгууллагын машин	Явах км	Зарцуулах шатахуун	Шатахууны үнэ /тег/рөгөөр/	Томилолтын нийт хоног	Томилолт гишүүд	Жолооч томилолтын хоног	Томилолт дүн	Дүн
Тонхил, Дарив	ХХААГ	600	120 л	336000	8	4	2	212000	548000
Алтай, Цээл, Бигэр	Статистикийн хэлтэс	1320	264 л	740000	8	4	4	212000	884000
Маягт хэвлэх									1500000
Нийт дүн			384 л	1076000	16	8	6	424000	30000000

__оОо__

Аймгийн Засаг даргын 2022 оны
11 дугаар сарын 11 ны өдрийн 4/67 дугаар
захирамжийн нэгдүгээр хавсралт

ГЦА0042

**МАЛ, ТЭЖЭЭВЭР АМЬТАД, ХАШАА, ХУДГИЙН
ТООЛЛОГО ХЯНАЛТЫН АЖЛААР ЯВАХ ЧИГЛЭЛ,
БҮРЭЛДЭХҮҮН**

№	Явах чиглэл	Ахлагч	Гишүүд
1	Тонхил, Дарив, Шарга	ХХААГ-ын дарга Т.Сүхбаатар	Статистикийн хэлтсийн ахлах мэргэжилтэн Б.Тогтохбаяр, ХХААГ-ын мэргэжилтэн Э.Пүрэвдорж
2	Алтай, Цээл, Бигэр	Статистикийн хэлтсийн дарга Д.Тунгалаг	Статистикийн хэлтсийн мэргэжилтэн Ч.Чулуунцэцэг, Г.Бурмаа

__оОо__